



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/31

Чойбалсан

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 87 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Коронавируст халдвар /ковид-19/ цар тахлын үеийн эмнэлгийн орны зохицуулалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, түр журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалыг хэрэгжилтийг хангаж ажиллахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрх, сумын эрүүл мэндийн төвийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Б.Гантуяад даалгасугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА

Эрүүл мэндийн газрын даргыноны
10... дугаар сарын 08... ны/ний өдрийн
А/31 дугаар/дүгээр тушаалын
нэгдүгээр хавсралт




КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/ ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН
ЭМНЭЛГИЙН ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: -Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
- Гишүүд: -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Чанарын албаны дарга
-Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга
- Зохицуулагч: -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмнэлзүйн эмч

oooOooo

Эрүүл мэндийн газрын даргын оны
10.. дугаар сарын 08..ны/ний өдрийн
#131.....дугаар/дүгээр тушаалын
хоёрдугаар хавсралт



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/ ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ТҮР ЖУРАМ

Нэг. Үндэслэл:

Дорнод аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тохиолдлын тоо өсч, эмнэлгийн тусламж, үйлчилгээ шаардлагатай өвчтний тоо тогтмол нэмэгдэж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл үүсч, өвчтний биеийн байдал хүндэрсний дараа эмнэлгийн тусламж үйлчилгээ авснаар хэвтэн эмчлүүлэх орны эргэлт удааширч, орны хүлээгдэл нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор эмнэлгүүдэд нэмэлт ор дэлгэн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээг нэмэгдүүлж байгаа боловч өвчтнийг эрт илрүүлж, зөв эрэмбэлэн ангилж, тохирсон тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд эрүүл мэндийн бүх түвшний байгууллагын удирдлага, зохион байгуулалт, уялдаа холбоог сайжруулах асуудал чухлаар тавигдаж байна.

Цаашид эрэмбэлэн ангилалтыг хяналттай болгож, мэдээллийг цахимжуулж, бодит цаг хугацаанд мэдээлэл солилцох ажлыг сайжруулснаар орны зохицуулалтыг эрэмбэлэн ангилсан бодит үнэлгээнд үндэслэн, үйлчлүүлэгчид шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Хоёр.Зорилго:

Коронавируст халдвар /КОВИД-19/-тай өвчтөнийг эмнэлзүйн эрэмбийн дагуу эмнэлэгт хэвтүүлэх, эмнэлэг хооронд шилжүүлэх, орны ачааллыг зохистой хуваарилах, орны зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах

Гурав. Хамтран ажиллах байгууллага:

Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын тасаг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрх, сумын эрүүл мэндийн төв, ор дэлгэсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа:

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн хугацаанд

Тав. Хамрах хүрээ:

Аймгийн хэмжээнд Коронавируст халдвар /Ковид-19/ -ын ор дэлгэн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд

Зургаа: Үйл ажиллагааны чиглэл:

6.1.Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон бусад Коронавируст халдвар /Ковид-19/-тай иргэнд хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлэхээр ор дэлгэн ажиллаж байгаа эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх зохицуулалтыг хийнэ.

6.2.Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь Коронавируст халдвар /Ковид-19/-ын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа ор зохицуулалтын байдалд өдөр бүр цахимаар хяналт хийж нэгдсэн удирдлага, зөвлөмжөөр ханган удирдлагыг бодит мэдээллээр хангана.

6.3.Хүндрэх эрсдэлтэй хөнгөн хэлбэр, хүнд, хүндэвтэр өвчтнүүдийг яаралтай эрэмбэлэн өрхийн Эрүүл мэндийн төвийн хариу арга хэмжээний багийн ахлагч нь Бүсийн оношилгоо төвийн зохицуулагч эмчид тухай бүр мэдээлнэ. Зохицуулагч эмч өвчтнийг яаралтай эрэмбэлэн орны зохицуулалтыг хийж хэвтүүлнэ.

6.4.Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хариу арга хэмжээний багийн ахлагч нар хүндрэх эрсдэлтэй өвчтнүүдийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Ковидын амбулаторит үзүүлж, хэвтэх орны зохицуулалтад оруулна.

6.5.Сумын эрүүл мэндийн төвөөс хүнд, нэн хүнд өвчтнийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шилжүүлэх асуудлаа ор зохицуулах багт урьдчилан танилцуулж, багийн ахлагч нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал Ж.Энхчимэгт танилцуулан өвчтнийг тээвэрлэх эсэхээ шийдвэрлэнэ.

6.6.Өдөр бүр яаралтай тусламжийн орыг багадаа 20 хүртэл хувийг суллаж Коронавируст халдвар /Ковид-19/-тэй иргэдэд хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлж байгаа тасаг, нэгжүүдэд шилжүүлнэ.

6.7.Тухайн эрүүл мэндийн байгууллага хүчилтөрөгчтэй тээвэрлэлт хийх тоноглогдсон автомашингүй тохиолдолд 7058103 тусгай дугаарт дуудлага өгч тусгай тоноглогдсон автомашин болон бусад тээврийн хэрэгслийг ашиглан эмнэлэг хооронд тээвэрлэх асуудлыг зохицуулна.

6.8.Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдаж байгаа яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай иргэдэд 7058103 тусгай дугаарт дуудлага өгч Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шилжүүлнэ.

6.9 Ажлын хэсэг нь Коронавируст халдвар /Ковид-19/-тэй өвчтөнийг эрэмбийн дагуу эмнэлэгт хэвтүүлэх, эмнэлэг хооронд шилжүүлэх орны ачааллыг зохистой хуваарилж зохион байгуулалтыг хийх албан хаагчдын нэрс, ажиллах хуваарийг гарган хяналт тавьж ажиллана.

6.10.Эмнэлэг хооронд шилжүүлэх асуудлыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2021 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн 08/1266 тоот албан бичгийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо: Хүрэх үр дүн:

7.1.Коронавируст халдвар /Ковид-19/-тэй хүнд, маш хүнд өвчтөнг зөв эрэмбэлж цаг алдалгүй эмнэлэгт хэвтүүлж тусламж, үйлчилгээ үзүүлснээр нас баралтыг бууруулна.

7.2.Коронавируст халдвар /Ковид-19/ батлагдаж хэвтэн эмчлүүлж байгаа өвчтний хүндрэлийн зэргээс хамааран орны эргэлт, ашиглалтыг сайжруулснаар орны ачаалал, хүлээгдэл буурч тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирна.